



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ӨМА-2022/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	94.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,442.5
	Нийт хөрөнгийн дүн	2,537.1
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,532.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,532.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	488.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	477.3
	Үйл ажиллагааны үр дүн	11.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	-0.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	10.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652.3
	Тайлант оны үр дүн	1,884.8
	Эцсийн үлдэгдэл	2,537.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	485.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	464.4
	Үйл ажиллагааны ЦМГ	21.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-21.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	470.5
	Урсгал зардал	470.5
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	470.5
	Улсын төсвөөс санхүүжих	424.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46.4



Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ									

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 68 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 зүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 7 дугаар зүйлийн 7.1 “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тав. Аудитын үр дүн

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11



1	ТШЗ	11	4,615.4	5	1,909.7		1	2,554.2	6	151.5
2	Төсөл, хөтөлбөр									
3	ЗГТС									
4	ТТЗ									
5	ТЕЗ									
	НИЙТ	11	4,615.4	5	1,909.7		1	2,554.2	6	151.5

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 4,615.4 сая төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 1,909.7 сая төгрөгийн 5 алдааг залруулж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 2,554.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 151.5 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Санхүү байдлын тайлан дахь нийт хөрөнгийн дүнг үндсэн хөрөнгийн тайлантай тулган баталгаажуулахад 1,843.5 төгрөгөөр, санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийг дүнг үндсэн хөрөнгийн тайлантай тулган баталгаажуулахад 11.1 сая төгрөгөөр, санхүү байдлын тайлан дахь бараа материалын үлдэгдэлийг няравын тайлантай тулган баталгаажуулахад 47.6 сая төгрөгөөр, Орлого үр дүнгийн тайлангийн шуудан холбоо, интернетийн төлбөр зардлыг өглөгийн тайлантай тулган баталгаажуулахад 0.9 сая төгрөгөөр, Орлого үр дүнгийн тайланд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгийг 1.2 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгийг 5.3 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан алдааг аудитын явцад залруулав.

Албан шаардлага

Жилийн эцэст 2,537.1 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 16.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, урсгал засварын зардлаас 0.5 сая төгрөгийн компьютер, принтерийн засварын үнэ төлсөн, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 0.6 сая төгрөгийн тоглолтын хувцас, чүүл авсан, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл зардлаас 4.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Үндсэн хөрөнгийн тайланд үлдэх өртөггүй 28 ширхэг хөрөнгө бүртгэлтэй, ёанхүүгийн тайлан дахь аж ахуйн материалын дансанд 106 нэр төрлийн 459 ширхэг 20.3 сая төгрөгийн сургалтын ном, хэрэглэгдэхүүн, тоглоом бүртгэлтэй, Тайланд онд байгууллагын ажилчдад илүү цагийн хөлс олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг баримтлаагүй зэрэг зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.



Зургаа. Аудитын санал дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.02.23 № 157
танай _____ -ны № _____ -г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цогт-Овоо сумын 12-р цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцэст 2,537,104,936.73 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 15,999,800 төгрөг, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 4,428,680 төгрөг, урсгал засварын зардлаас 505,000 төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 624,600 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.



Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЦЭРЭНБАЯР